



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 04 сарын 28 өдөр

Дугаар А/62

Улаанбаатар хот

Сургалтад хамруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.9 дэх заалт, Хөдөлмөрийн дотоод журмын 3.27.1 дэх заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 4.2.6 дахь заалт, "Иргэний нисэхийн ерөнхий газрын 2023 оны төлбөртэй дотоод сургалтын төлөвлөгөөг"-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."АЙ СИ ТИ ТРЭЙНИНГ ХХК"-аас 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 05-ны өдрүүдэд танхимаар зохион байгуулах Cisco CCNA-ын сүлжээний сургалтад Мэдээллийн аюулгүй байдал, технологийн албаны сүлжээний инженер М.Ган-Очирыг хамруулсугай.

2.Сургалтын төлбөрт нийт 1,200,000 (нэг сая хоёр зуун мянга) төгрөгийг зохих журмын дагуу зарцуулахыг Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газар (Д.Пүрэв-Очир)-т зөвшөөрсүгэй.

3.Ажил үүрэгт нь зохицуулалт хийж, сургалтад бүрэн хамруулахыг Мэдээллийн аюулгүй байдал, технологийн алба (Г.Цэвээнгэрэл)-д үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн газар (Э.Нарантунгалаг)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ХАВСРАН  
ГҮЙЦЭТГЭГЧ



Н.БАТСАЙХАН

1723 01 0436